



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/42

Мандалговь

"Номгоноос Өлзийтмандал хүртэлх автозам, 7
явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны
тохижилтын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ
худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх
заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Номгоноос Өлзийтмандал
хүртэлх автозам, явган хүний замын засвар, гэрэлтүүлэг, далан шуудууны
тохижилтын ажил"-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах
бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---------------------------|---|
| Үнэлгээний хорооны дарга: | Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга) |
| Гишүүд: | Б.Мижиддорж (Иргэний төлөөлөл) Э.Энхмэнд (Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга) Б.Төвшинжаргал (Онцгой байдлын газрын нягтлан бодогч) |
| Нарийн бичиг: | Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн Газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн) |

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



4822150093